



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс  
урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах  
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/632 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хүндсуртлыг багасгах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дүүргийн Аж ахуйн нэгж, байгууллага, ажилтан, албан хаагч, иргэдийн үйл ажиллагаатай холбогдуулан Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв" дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийн, зохих арга хэмжээ авч, Авлигын индексийг бууруулах ажлын хэсэг болон холбогдох байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан ажиллахыг Ажлын хэсэг (Л.Санжийжамц)-т зөвлөсүгэй.

3. Төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулж, ажлын явц, үр дүнг 14 хоног тутам Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлж ажиллахыг Ажлын хэсэг (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЭРДЭНЭБАЯР

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2021 оны 10 дугаар сарын 05 ны өдрийн  
2168 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН


Ажлын хэсгийн  
ахлагч:  
Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын дарга  
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга  
Тохижилт, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн  
дарга  
Цэргийн штабын дарга  
1 дүгээр хорооны Засаг дарга  
2 дугаар хорооны Засаг дарга  
Дотоод аудитын албаны дарга  
Худалдан авах ажиллагааны албаны дарга  
Газар зохион байгуулалтын албаны дарга  
Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн дарга  
Нийгмийн даатгалын хэлтсийн дарга  
Цагдаагийн хэлтсийн дарга  
Онцгой байдлын хэлтсийн дарга  
Татварын хэлтсийн дарга  
Боловсролын хэлтсийн дарга  
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга  
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга  
Эрүүл мэндийн төвийн дарга  
Хангай цогцолбор сургуулийн захирал  
44 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч  
207 дугаар цэцэрлэгийн эрхлэгч  
Биеийн тамир, спорт хорооны дарга  
Соёлын ордны захирал  
Мэргэжлийн хяналтын тасгийн улсын байцаагч  
Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон  
хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан  
тушаалтан /байгууллагын ЭБАТ-ууд/

Нарийн бичгийн  
дарга:

Засаг даргын Тамгын газрын Эрх зүй, хяналт, шинжилгээ-  
үнэлгээ, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2021 оны 10 сарын 25-ны өдрийн 7169 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| №                                  | Хэрэгжүүлэх арга хэмжээ   | Хугацаа        | Төсөв<br>/мянга<br>төгрөгөөр/ | Хариуцах байгууллага          |             |
|------------------------------------|---|----------------|-------------------------------|-------------------------------|-------------|
|                                    |   |                |                               | Үндсэн                        | Хамтрагч    |
| Нэг. Зохион байгуулалтын чиглэлээр |   |                |                               |                               |             |
| 1.1                                | Авлига, хүнд суртлыг таслан зогсоох арга хэмжээ авах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын явц, үр дүнг дүүргийн Засаг даргын зөвлөлийн гишүүдэд танилцуулж ажиллах                                  | 14 хоног тутам | -                             | Ажлын хэсэг                   | ААНБ        |
| 1.2                                | Нийслэлийн Авлигын индексийг бууруулах ажлын хэсэгтэй үйл ажиллагаагаа уялдуулж, мэдээ мэдээллээр хангаж ажиллах  | Тогтмол        | -                             | Ажлын хэсэг                   | ААНБ        |
| 1.3                                | Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах   | Тухай бүр      | -                             | Ажлын хэсэг                   | Хороод ААНБ |
| 1.4                                | Төрийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээ, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдалд хяналт, шалгалт хийх | 7 хоног тутам  | -                             | Хяналт, шалгалтын ажлын хэсэг | Ажлын хэсэг |
| 1.5                                | Иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэлд үндэслэн тухайн байгууллагад хяналт, шалгалт хийж, гарсан зөрчлийг арилгуулах   | Тухай бүр      | -                             | Хяналт, шалгалтын ажлын хэсэг | Ажлын хэсэг |
| 1.6                                | Иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд холбогдох авлига, хүнд суртал, төрийн албан   | Тухай бүр      | -                             | Ажлын хэсэг                   | ААНБ        |

|   |   |             |         |                               |              |
|---|---|-------------|---------|-------------------------------|--------------|
|   | хаагчийн ёс зүйтэй холбоотой гаргасан гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх  |             |         |                               |              |
| 1.7   | Хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний явц, үр дүнг авч хэлэлцэх  | Тухай бүр   | -       | Хяналт, шалгалтын ажлын хэсэг | Ажлын хэсэг  |
| 1.8   | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд” мэдээллийн самбар хийлгэх байршуулах  | Жилдээ      | 500.000 | Ажлын хэсэг                   | ТЗБ          |
| Хоёр. Төрийн байгууллагын ил тод байдал, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр |   |             |         |                               |              |
| 2.1   | Нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээ, үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв, санхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдлан авах ажиллагааны ил тод байдалд хяналт тавих | Тогтмол     | -       | Ажлын хэсэг                   | ААНБ         |
| 2.2   | Захиргааны байгууллагуудын ёс зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн албан хаагчдын ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчилд дүн шинжилгээ хийх, түүнийг арилгах арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах                     | Тухай бүр   | -       | Ажлын хэсэг                   | ААНБ         |
| 2.3   | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр видео шторк, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг хэвлүүлэх, байгууллагын цахим хуудаст байршуулж, мэдээллэх   | 1 жил       | -       | Ажлын хэсэг                   | ААНБ, Хороод |
| 2.4   | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шудрага ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах  | 4-р улиралд | 500.000 | ЗДТГ                          | ААНБ         |
| 2.5   | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах  | Тогтмол     | -       | Ажлын хэсэг                   | Хороод, ААНБ |

|   |  |                     |   |                             |              |
|---|--|---------------------|---|-----------------------------|--------------|
|   | үйл ажиллагааг зохион байгуулах  |                     |   |                             |              |
| 2.6   | Боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах  | Тогтмол             |   | Дүүргийн боловсролын хэлтэс | СӨБ, ЕБС     |
| Гурав. Иргэдийн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр |  |                     |   |                             |              |
| 3.1   | Иргэдээс нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гаргасан гомдол, мэдээллийг эрэмбэлж, байгууллага тус бүрээр дүн шинжилгээ хийх | 7 хоног тутам       | - | Ажлын хэсэг                 | ААНБ         |
| Дөрөв. Бусад  |  |                     |   |                             |              |
| 4.1   | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Нэг ЭБАТ-Нэг арга хэмжээ” зохион байгуулах  | 2 сар тутам         | - | Дүүргийн ЭБАТ-ууд           | ААНБ, Хороод |
| 4.2   | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд хамрагдах, хамтран ажиллах  | Тухай бүр           | - | Ажлын хэсэг                 | ААНБ         |
| 4.3   | Иргэдээс авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх санал асуулга авах  | Хагас, бүтэн жилээр | - | Ажлын хэсэг                 | Хороод ЭБАТ  |